



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГЛАННУУР СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 0001

Гурван сайхан


Цаа буга худалдан борлуулахыг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэг, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/198 дугаар тушаалын 6.4, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Цаа бугын тоо толгойг ёсгөн нэмэгдүүлэх, цаатны ёс заншил, өв соёлыг хадгалах, цаа бугыг мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг хамгаалах, цаатан иргэдийг арилжааны зорилгоор цаа бугыг өөр бүс нутагт худалдан борлуулж дасан зохицох чадварыг нь алдагдуулахгүй байх зорилгоор тайгын тэтгэмж авч байгаа иргэдийг өөр бүс нутагт цаа бугыг худалдан борлуулахгүй, сумын нутаг дэвсгэрээс цаа бугыг удаан хугацаагаар гаргахгүй байхыг анхааруулсугай.
- Холбогдох хууль, журмыг зөрчсөн иргэнийг тайгын тэтгэмжид хамруулахгүй байхыг сумын Амьжирагааг дэмжих зөвлөлд үүрэг болгосугай.
- Цаа бугыг худалдан борлуулах болон удаан хугацаагаар сумын нутаг дэвсгэрээс гаргах зайлшгүй шаардлага бий болсон гэж үзсэн тохиолдолд сумын Засаг даргаас заавал зөвшөөрөл авахыг иргэдэд мэдэгдсүгэй.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргад даалгасугай.

ДАРГА

Д.ОТГОНСҮРЭН



672501014